



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2021 оны 04 сарын 05 өдөр

Дугаар 101

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас
хасах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.4.4, 6.6 дахь заалт, 2019 оны “Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай” 268 дугаар тогтоолын 4.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Байгаль орчин, аялал жуулчлалын яамны харьяа Туул голын сав газрын захиргааны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, сэргээн засварлах боломжгүй болсон, хоёр удаагийн нээлттэй дуудлагын худалдаанд оролцогч ирээгүй нийт 26,956,000.00 (хорин зургаан сая есөн зуун тавин зургаан мянган) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан автомашиныг акталж данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2.Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Ганболд, Туул голын сав газрын захиргааны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Мэдээлэл, хяналт шалгалтыг зохицуулах албаны дарга Б.Оюунболд нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хавсралтад заасан үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах, сэлбэгээр худалдах ажлыг хууль тогтоомж, журмын дагуу Байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3.Акталж, данснаас хассан автомашиныг улсын дугаарыг улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс хасуулсан тодорхойлолт, дээрх арга хэмжээний биелэлтийг 2021 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-г үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132001289

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2021 оны 11 дугаар сарын 3 өдрийн
101 дугаар тогтоолын хавсралт

**БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМНЫ ХАРЬЯА
ТУУЛ ГОЛЫН САВ ГАЗРЫН ЗАХИРГААН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ,
АКТЛАН ДАНСНААС ХАСАХ АВТОМАШИН**

№	Автомашины марк, улсын дугаар, зориулалт, арлын дугаар	Ашиглалт ад орсон огноо	Нийт км	нийт үнэ, хуримтлагдсан элэгдэл
				/төгрөг/
1	Хонда аккорд, УБЗ 62-79, арал-JHMCL76405C213124	2017	129129	26,956,000.00
	НИЙТ ДҮН			26,956,000.00
				(хорин зургаан сая есөн зуун тавин зургаан мянга)